ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 95

танай __________-ны №__________-т

ХАЙРХАНДУЛААН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Д.ХОРЛОО
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хайрхандулаан сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хайрхандулаан сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд 2023 онд өөрчлөлт орсон. Тайлант онд 400.0 цэцэрлэгийн өргөтгөлийн шинэ барилгатай болсон. Улсын төсвөөс 444.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 35.8 сая төгрөг, нийт 480.2 сая төгрөгийн санхүүжилт авч 8-н хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан. Мөн 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, БЕГазраас хөрөнгө оруулалтаар ирсэн 12.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад нэг бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус байгууллагын хувьд жилийн эцэст төсвийн харилцах данснадаа 92.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

*2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **58103163.20** | **143568288.23** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 16799847.00 | 92768905.03 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 16799847.00 | 92768905.03 |
| 3121 | **Төгрөг** | 16799847.00 | 92768905.03 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 16799847.00 | 92768905.03 |
| 33 | **АВЛАГА** | 0.00 | 327105.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 327105.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 41303316.20 | 50472278.20 |
| 351 | **Түүхий эд материал** | 2238570.00 | 2407070.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2238570.00 | 2407070.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 39064746.20 | 48065208.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 143800.00 | 154800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2224700.00 | 3304800.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1235000.00 | 1235000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2262890.00 | 5262952.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 33198356.20 | 38107656.20 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **252312714.97** | **640834604.59** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 252312714.97 | 640834604.59 |
| 392 | **Биет хөрөнгө** | 246612714.97 | 635359604.59 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 236686516.59 | 636686516.59 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -34004521.95 | -44123942.10 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 38502796.40 | 40273548.10 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -11272314.94 | -19469111.56 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15755107.48 | 27781107.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7958005.45 | -13158360.28 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 3000000.00 | 3000000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -1200000.00 | -1500000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12389659.00 | 12389659.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6937192.16 | -8170482.64 |
| 39217 | Ном | 1650670.00 | 1650670.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 5700000.00 | 5475000.00 |
| 39301 | Програм хангамж | 1670000.00 | 1670000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -770000.00 | -995000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4800000.00 | 4800000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **310415878.17** | **784402892.82** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **310415878.17** | **784402892.82** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 310415878.17 | 784402892.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 407061581.00 | 407061581.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 407061581.00 | 407061581.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | -100755095.15 | 373231919.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -115447136.63 | -100755095.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 14692041.48 | 473987014.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4109392.32 | 4109392.32 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **310415878.17** | **784402892.82** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **579769494.69** | **892235551.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **313327336.69** | **411996751.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 313327336.69 | 411996751.70 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 313327336.69 | 411996751.70 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 313327336.69 | 411996751.70 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **266442158.00** | **480238800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 230923100.00 | 444453100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 230923100.00 | 444453100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 35519058.00 | 35785700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35519058.00 | 35785700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **269353616.52** | **418248537.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **269353616.52** | **418248537.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 265779616.52 | 415290571.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 172044904.00 | 272631258.46 |
| 210101 | Үндсэн цалин | 131813474.00 | 208764747.13 |
| 210102 | Нэмэгдэл | 30223680.00 | 54037094.33 |
| 210104 | Урамшуулал | 10007750.00 | 9829417.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21940097.00 | 34290093.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15077981.73 | 23539148.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1760887.09 | 2760268.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1388549.69 | 2172934.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 336276.39 | 524252.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3376402.10 | 5293489.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23731400.00 | 33579034.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1410200.00 | 2730822.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13876200.00 | 21748212.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8445000.00 | 9100000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1144500.00 | 18000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 55000.00 | 18000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 278600.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21585029.00 | 38248773.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21585029.00 | 38248773.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1305000.00 | 1500000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1305000.00 | 1500000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 444000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 444000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23584686.52 | 35023412.08 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3457600.00 | 7671300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1297400.00 | 2077250.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18829686.52 | 25274862.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3574000.00 | 2957965.66 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3574000.00 | 2251300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3574000.00 | 2251300.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 706665.66 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 706665.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **310415878.17** | **473987014.65** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **310415878.17** | **473987014.65** |

*2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **266442158.00** | **480238800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **266442158.00** | **480238800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 230923100.00 | 444453100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 230923100.00 | 444453100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 35519058.00 | 35785700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35519058.00 | 35785700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **248742311.00** | **402469741.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **248742311.00** | **402469741.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **245168311.00** | **399511776.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 172044904.00 | 272909131.46 |
| 210101 | Үндсэн цалин | 131813474.00 | 209042620.13 |
| 210102 | Нэмэгдэл | 30223680.00 | 54037094.33 |
| 210104 | Урамшуулал | 10007750.00 | 9829417.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21940097.00 | 34339325.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15077981.73 | 23480885.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1760887.09 | 2753449.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1388549.69 | 2193959.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 336276.39 | 534661.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3376402.10 | 5376369.51 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23731400.00 | 33579034.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1410200.00 | 2730822.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13876200.00 | 21748212.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8445000.00 | 9100000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 15399310.00 | 41248835.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15399310.00 | 41248835.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1500000.00 | 1500000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1500000.00 | 1500000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 444000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 444000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10108600.00 | 15935450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7858600.00 | 13858200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2250000.00 | 2077250.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3574000.00** | **2957965.66** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3574000.00 | 2251300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3574000.00 | 2251300.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 706665.66 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 706665.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **17699847.00** | **77769058.03** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **900000.00** | **1800000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **900000.00** | **1800000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 900000.00 | 1800000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 900000.00 | 1800000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-900000.00** | **-1800000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 16799847.00 | 75969058.03 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 16799847.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 16799847.00 | 92768905.03 |

*2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан*

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 407,061,581 | 4,109,392.32 | -115,447,136.63 | 295,723,836.69 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0.00 | -295,723,836.69 | - 295,723,836.69 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0.00 | 310,415,878.17 | 310,415,878.17 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **407,061,581** | **4,109,392.32** | **-100,755,095.15** | 310,415,878.17 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **407,061,581** | **4,109,392.32** | **-100,755,095.15** | 310,415,878.17 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **407,061,581** | **4,109,392.32** | **-100,755,095.15** | 310,415,878.17 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0.00 | 473,987,014.65 | 473,987,014.65 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **407,061,581** | **4,109,392.32** | **373,231,919.50** | 784,402,892.82 |

*2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 266442400 | 249642311.00 | 490991200 | 403563077.31 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 266442400 | 249642311.00 | 490991200 | 403563077.31 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 262868400 | 246068311.00 | 488739900 | 401311777.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 178408100 | 172044904.00 | 336423000 | 272909131.46 |
| 210101 | Үндсэн цалин | 151482400 | 131813474.00 | 230599000 | 209042620.13 |
| 210102 | Нэмэгдэл | 23852000 | 30223680.00 | 97836000 | 54037094.33 |
| 210104 | Урамшуулал | 3073700 | 10007750.00 | 7988000 | 9829417.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22400900 | 21940097.00 | 42052700 | 34339325.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15307800 | 15077981.73 | 28595900 | 23480885.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1800900 | 1760887.09 | 3364300 | 2753449.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1427300 | 1388549.69 | 2691400 | 2193959.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 351400 | 336276.39 | 672600 | 534661.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3513500 | 3376402.10 | 6728500 | 5376369.51 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23731400 | 23731400.00 | 34285700 | 33579034.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1410200 | 1410200.00 | 3234000 | 2730822.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13876200 | 13876200.00 | 21951700 | 21748212.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8445000 | 8445000.00 | 9100000 | 9100000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25375400 | 15399310.00 | 55538600 | 41248835.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25375400 | 15399310.00 | 55538600 | 41248835.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1500000 | 1500000.00 | 1500000 | 1500000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1500000 | 1500000.00 | 1500000 | 1500000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 444000 | 444000.00 | 692700 | 1.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 444000 | 444000.00 | 692700 | 1.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11008600 | 11008600.00 | 18247200 | 17735450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8758600 | 8758600.00 | 16169000 | 15658200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2250000 | 2250000.00 | 2078200 | 2077250.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3574000 | 3574000.00 | 2251300 | 2251300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3574000 | 3574000.00 | 2251300 | 2251300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3574000 | 3574000.0 | 2251300 | 2251300.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0** | **0.0** | **0** | **0.0** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 266442158 | 266442158.00 | 480238800 | 480238800 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 266442158 | 266442158 | 35785700 | 35785700.00 |
| | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 230923100 | 230923100 | 444453100 | 444453100 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 35519058 | 35519058 | 35785700 | 35785700 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0** | **0.0** | 0 | 16799847.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0** | **16799847.0** | 0 | 92768905.03 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 0 | 13.00 | 19 | 19.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 0 | 1.0 | 1 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 0 | 8.0 | 6 | 6.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0 | 4.0 | 12 | 12.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 0 | 0.00 | 125 | 125.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 0 | 0.00 | 125 | 125.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | | | 125 | 125.00 |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Зорилго-Өөртөө итгэлтэй эрүүл чийрэг хүнлэг энэрэнгүй иргэн болгон төлөвшүүлэх. Зорилт Бага насны хүүхдийг асран хамгаалах тэднийг тоглоомоор дамжуулан бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн зэрэг хүмүүжил олгох . Чиг үүрэг-Хүүхэд бүр аюулгүй ,тохилог орчинд бүтээлч үйлээр тоглонгоо хөгжиж төлөвшинө.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хайрхандулаан сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд 2023 онд өөрчлөлт орсон. байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг бусад хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Хайрхандулаан сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайрхандулаан сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хайрхандулаан сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй .

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 473.6 сая төгрөгөөр *өссөн* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 58103.2 | 92768.9 | 34665.7 |
| Авлага | 0 | 327.1 | 327.1 |
| Бараа материал | 41303.3 | 50472.3 | 9169.0 |
| Үндсэн хөрөнгө | 252312.7 | 640834.6 | 388521.9 |
| **Нийт хөрөнгө** | **310415.9** | **784402.9** | **473987.0** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 310415.9 | 7840402.9 | 473622.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **310415.9** | **784402.9** | **473987.0** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс өссөн шалтгаан нь:

Тайлант онд Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл урьд онтой харьцуулахад 34665.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө өссөн шалтган нь 400000,0 мянган төгрөгийн өргөтгөлийн шинэ байртай болсон. Худалдан авсан тавилга, тоног төхөөрөмж 1800.0 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтаар 11996.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн.Тайлант оны элэгдлийн зардал 25274.9 мянган төгрөг болсон нь гол нөлөөг үзүүлжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь төсвийн төслөө цахимаар хийдэг болсон. 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 446.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.Төсвийн төслийн саналаас урсгал үйл ажиллагааны зардлыг 2.1 сая төгрөгөөр илүү, тогтмол зардлыг төсвийн саналаар тооцон баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 480.2 сая төгрөгийг төсвийг баталсан. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 444.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 35.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 402.5 сая төгрөг буюу 84 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин хөлсний зардлын төсвийг 59.7 сая төгрөгөөр хүүхдийн хоолны зардлын төсвийг 9.5 сая төгрөгөөр, Нүүдлийн бүлэгт хамруулах зардлыг 9.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71801/81834 Боловсролын стандарт,сургалтын төлөвлөгөө , хөтөлбөр хэрэгжүүлэх | 299529.7 | 234240.6 | 65289.1 | 78 |
| 2 | 71801/81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах | 72005.2 | 69601.6 | 2403.6 | 97 |
| 3 | 71801/81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 45420.8 | 35903.5 | 9517.3 | 79 |
| 4 | 71801/81605Эрүүл мэндийг дэмжих | 1039.1 | 800.0 | 239.1 | 77 |
| 5 | 71801/81816 Зөв монгол хүүхэд хөтөлбөр | 3715.8 | 3679.5 | 36.3 | 99 |
| 6 | 71801/81823 Боловсролын байгууллагын багш,ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 1039.1 | 1016,0 | 23.1 | 98 |
| 7 | 71801/80111Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 35785.7 | 35785.7 | 0.0 | 100 |
| 8 | 71801/81832 Нүүдлийн бүлэгт хамруулах | 32455.8 | 23242.8 | 9213.0 | 72 |
| | | | | | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тус байгууллагын хувьд нэмэлт төсөв, санхүүжилт аваагүй байна.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хүрээнд 2023 онд тус цэцэрлэг 2 удаа тендер зарласан боловч байгууллагууд санал ирүүлээгүй, шууд худалдан авалтаар 7 байгууллагатай бүтээгдэхүүн ажил үйлчилгээ худалдан авах гэрээ хийсэн.Үүнд:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал- 45420.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн үйлчилгээ-800.0 мянган төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардалд 4676.0 мянган төгрөг, Тавилга,тоног төхөөрөмж -1800.0 мянган төгрөгөөр худалдан авсан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хайрхандулаан сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Дөлгөөнхайрхан Уул Аудит" ХХК-ын аудитор Д.Дашзэвэг,аудиторын туслах Д.Даваасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайрхандулаан сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Дөлгөөнхайрхан Уул Аудит" ХХК-нд 2024 оны 02 дугээр сарын 14-ны өдрийн 07 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зарлагын 269.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.

Энэ хуулийн хүрээнд цалин хөлсний зардал, хүүхдийн хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, Нүүдлийн бүлэгт хамруулах зардлуудыг хэмнэсэн. Төсвийн харилцах дансанд 92.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан. Хүүхдийн хоолны зардал хэмнэсэн шалтгаан нь хүүхдийн ирцтэй холбоотой байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзсэн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.
<u>Шийдвэрлэсэн нь</u>:
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 9-р сарын мэдээллийг, Аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн 344.5 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний мэдээлэл оруулаагүй 43048.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд тус байгууллагын хувьд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 1 | 344.5 | 1 | 344.5 | . 100 |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **344.5** | **1** | **344.5** | |

Өмнөх аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой 1 албан шаардлагын зөрчлийг таслан зогсоосон .

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл, өглөг авлагын тооцоо, цалингийн тооцоолол бүртгэлийн бичилт.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цалингийн авлагыг тайланд тусгалгүй орхисон 311,1 мянган төгрөгийн алдааг тайлангийн явцад залруулсан

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг 1939.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтээр аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн 344.5 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний мэдээлэл оруулаагүй 43048.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгсөн

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тавигдах зөрчил илрээгүй.

### 5.2 Албан шаардлага

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг 1939.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан 1 албан шаардлага өгсөн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн 344.5 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний мэдээлэл оруулаагүй 43048.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй .

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн авлага тайланд тусгаагүй | 1 | 311.1 | 0 | 311.1 | 0 | 0 | 1 | 311.1 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын норматив хэтрүүлэн зарцуулсан | 1 | 1939.4 | 0 | 0 | 1 | 1939.4 | | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| ДҮН | 1 | 1939.4 | 0 | 0 | 1 | 1939.4 | | 0 | 0 | 0 | 0 | 0 |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон,орхигдуулсан | 1 | 43393.3 | 0 | 0 | 1 | 43393.3 | 0 | 0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 43393.3 | 0 | 0 | 1 | 43393.3 | 0 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 0 | 0 0 | 0 0 | 0 0 | 0 0 | 0 0 | 0 |
| Нийт дүн | 0 0 | 0 0 | 0 0 | 0 0 | 0 | 0 0 | 0 0 | 0 |

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил гараагүй.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР